

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2024/240/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Санхүү нийцлийн хэлтсийн дарга,	
Улаанбаатар хот	Аудитын менежер:	Х.Түвшинбаяр
2024 он	Утас: Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a>	
	Аудитын менежер:	Я.Алтанцэцэг
	Утас: Цахим хаяг: <a href="mailto:altantsetsegya@audit.gov.mn">altantsetsegya@audit.gov.mn</a>	
	Ахлах аудитор:	Ё.Лхагвадулам
	Утас: Цахим хаяг: <a href="mailto:lkhagvadulamyo@audit.gov.mn">lkhagvadulamyo@audit.gov.mn</a>	
	Аудитор:	Б.Ариунзаяа
	Утас: Цахим хаяг: <a href="mailto:ariunzayaba@audit.gov.mn">ariunzayaba@audit.gov.mn</a>	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.02.23 № 452

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН ХҮНС, ХӨДӨӨ  
АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА,  
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ  
Х.ЭРДЭНЭБИЛЭГ ТАНАА

### АУДИТЫН ДҮГНЭЛТ

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой онцлог асуудлыг нэгтгэн харуулав.

Тайланд онд байгууллагын бүтэц өөрчлөгдөж, орон тоо нэмэгдсэн.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус газрын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

#### Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 41 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>167,229,921.5</b>	<b>199,323,615.5</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	127,076,411.0	119,216,411.0
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,003,711.0	3,003,711.0
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	124,072,700.0	116,212,700.0
3351	Байгууллагаас авах авлага	124,072,700.0	116,212,700.0
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	9,635,463.0	49,589,157.0
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	9,635,463.0	49,589,157.0
35410	Бичиг хэргийн материал	1,201,651.0	2,398,640.0
35420	Аж ахуйн материал	5,730,626.0	530,400.0
35440	Түлш, шатах тослох материал	1,390,000.0	656,640.0
35470	Бусад хангамжийн материал	1,313,186.0	46,003,477.0
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	30,518,047.5	30,518,047.5
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	30,518,047.5	30,518,047.5
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,003,137,431.8</b>	<b>4,056,035,214.0</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,003,137,431.8	4,056,035,214.0
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	70,984,008.7	2,124,441,790.8
39201	Барилга, байгууламж, орон сууц	-	811,010,000.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(18,022,444.4)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	122,275,376.0	359,830,376.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(83,554,840.1)	(186,938,371.0)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	69,641,933.8	945,740,682.3
39206	Хуримтлагдсан элэгдэл	(37,610,785.3)	(180,226,506.7)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,847,662.8	106,950,112.6
39208	Хуримтлагдсан элэгдэл	(34,615,338.5)	(66,227,805.6)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	365,813,215.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(13,487,467.3)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	1,932,153,423.2	1,931,593,423.1
39301	Програм хангамж	24,250,000.0	24,750,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(23,596,666.8)	(24,656,666.9)

Нийслэлийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

39303	Бусад биет бус хөрөнгө	1,932,000,090.0	1,931,500,090.0
39304	Хуримтлагдсан элэгдэл	(500,000.0)	-
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,170,367,353.3</b>	<b>4,255,358,829.5</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>30,438,875.8</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	30,438,875.8
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	30,438,875.8
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	30,438,875.8
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,170,367,353.3</b>	<b>4,224,919,953.7</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,170,367,353.3	4,224,919,953.7
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,976,997,354.0	1,976,997,354.0
51101	Өмч: - төрийн	1,976,997,354.0	1,976,997,354.0
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	193,036,824.7	2,247,589,425.1
51210	Өмнөх үеийн үр дүн	120,532,230.1	193,036,824.7
51220	Тайлант үеийн үр дүн	72,504,594.7	2,054,552,600.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	333,174.6	333,174.6
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,170,367,353.3</b>	<b>4,255,358,829.5</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>667,940,737.5</b>	<b>5,790,090,915.3</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>80,487,737.5</b>	<b>3,037,575,435.4</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	80,487,737.5	3,037,575,435.4
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	80,487,737.5	3,037,575,435.4
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	80,487,737.5	
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		2,090,483,668.4
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		947,091,767.0
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>587,453,000.0</b>	<b>2,752,515,479.9</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	25,840,000.0	35,713,047.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,000,000.0	18,315,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны	14,840,000.0	14,474,452.0

Нийслэлийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,923,595.0
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	561,613,000.0	2,716,802,432.9
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	561,613,000.0	2,716,802,432.9
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>595,436,142.8</b>	<b>3,735,538,314.9</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>595,436,142.8</b>	<b>3,735,538,314.9</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	569,633,150.8	3,681,889,614.9
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	405,871,642.0	1,938,835,294.8
210101	Үндсэн цалин	258,819,042.0	1,219,406,535.2
210102	Нэмэгдэл	79,471,680.0	347,956,843.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	35,292,389.0	181,442,157.0
210104	Урамшуулал	32,288,531.0	190,029,759.5
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	44,639,800.0	244,729,781.2
210201	Тэтгэврийн даатгал	26,904,382.0	167,555,630.5
210202	Тэтгэмжийн даатгал	5,260,645.0	19,777,485.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,536,219.0	15,540,390.0
210204	Ажилгүйдлийн даатгал	868,736.0	3,800,037.7
210205	Эрүүл мэндийн даатгал	7,069,818.0	38,056,237.8
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	4,399,200.0	36,304,600.0
210304	Байрны түрээс	4,399,200.0	36,304,600.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	19,228,409.0	76,543,666.7
210401	Бичиг хэрэг	4,829,130.0	14,609,960.0
210402	Тээвэр, шатахуун	9,015,350.0	25,611,150.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,585,220.0	4,266,303.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	147,400.0
210408	Бараа материал акталсны зардал	2,798,709.0	31,908,853.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	8,983,400.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	49,500.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	2,000,000.0
210604	Урсгал засвар	-	6,933,900.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	18,413,144.0	195,038,659.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,970,000.0	184,039,752.0
210803	Даатгалын үйлчилгээ	-	650,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	350,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	100,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	725,000.0	478,000.0
210807	Газрын төлбөр	2,718,144.0	6,818,907.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	2,602,000.0

Нийслэлийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	77,080,955.8	1,181,454,213.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,511,500.0	1,049,458,837.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	33,569,455.8	131,995,376.3
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	25,802,992.0	53,648,700.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	7,750,000.0	52,547,060.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	24,512,224.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,750,000.0	28,034,836.0
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	18,052,992.0	1,101,640.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,052,992.0	1,101,640.0
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>72,504,594.7</b>	<b>2,054,552,600.4</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>72,504,594.7</b>	<b>2,054,552,600.4</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>587,790,978.0</b>	<b>2,752,515,479.9</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>587,790,978.0</b>	<b>2,752,515,479.9</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	26,177,978.0	35,713,047.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,000,000.0	18,315,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,840,000.0	14,474,452.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	337,978.0	2,923,595.0
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	561,613,000.0	2,716,802,432.9
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	561,613,000.0	2,716,802,432.9
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>557,790,978.0</b>	<b>2,658,105,989.9</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>557,790,978.0</b>	<b>2,658,105,989.9</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>531,987,986.0</b>	<b>2,604,457,289.9</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	405,871,642.0	1,908,396,419.0
210101	Үндсэн цалин	258,819,042.0	1,193,616,904.5
210102	Нэмэгдэл	79,686,700.0	343,307,598.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,819,500.0	181,442,157.0
210104	Урамшуулал	32,546,400.0	190,029,759.5
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	44,639,800.0	244,729,781.2

Нийслэлийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	26,904,382.0	167,555,630.5
210202	Тэтгэмжийн даатгал	5,332,800.0	19,777,485.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,266,200.0	15,540,390.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,066,600.0	3,800,037.7
210205	Эрүүл мэндийн даатгал	7,069,818.0	38,056,237.8
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	4,399,200.0	36,304,600.0
210304	Байрны түрээс	4,399,200.0	36,304,600.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,182,700.0	47,423,493.7
210401	Бичиг хэрэг	3,402,130.0	16,332,000.0
210402	Тээвэр, шатахуун	10,195,350.0	24,877,790.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,585,220.0	4,266,303.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,947,400.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	23,568,500.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	3,198,500.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	14,370,000.0
210604	Урсгал засвар	-	6,000,000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	18,323,144.0	203,304,959.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,840,000.0	191,994,052.0
210803	Даатгалын үйлчилгээ	-	650,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	350,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	100,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	765,000.0	588,000.0
210807	Газрын төлбөр	2,718,144.0	6,818,907.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	2,804,000.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	42,571,500.0	140,729,537.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,571,500.0	140,729,537.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>25,802,992.0</b>	<b>53,648,700.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	7,750,000.0	52,547,060.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	24,512,224.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,750,000.0	28,034,836.0
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	18,052,992.0	1,101,640.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,052,992.0	1,101,640.0
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>30,000,000.0</b>	<b>94,409,490.0</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	-	<b>94,409,490.0</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>94,409,490.0</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	94,409,490.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	30,000,000.0	94,409,490.0

Нийслэлийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(30,000,000.0)	(94,409,490.0)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,976,997,354.00	333,174.59	120,532,230.07	2,097,862,758.66
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,976,997,354.00	333,174.59	120,532,230.07	2,097,862,758.66
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	72,504,594.67	72,504,594.67
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,976,997,354.00	333,174.59	193,036,824.74	2,170,367,353.33
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,976,997,354.00	333,174.59	193,036,824.74	2,170,367,353.33
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,976,997,354.00	333,174.59	193,036,824.74	2,170,367,353.33
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	2,054,552,600.38	2,054,552,600.38
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,976,997,354.00	333,174.59	2,247,589,425.12	4,224,919,953.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,893,840,800.0	2,716,802,432.9	177,038,367.1	93.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,893,840,800.0	2,716,802,432.9	177,038,367.1	93.9

Нийслэлийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,836,294,700.0	2,664,255,372.9	<b>172,039,327.1</b>	<b>93.9</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,045,821,700.0	1,908,396,419.0	<b>137,425,281.0</b>	<b>93.3</b>
210101	Үндсэн цалин	1,221,630,200.0	1,193,616,904.5	<b>28,013,295.5</b>	<b>97.7</b>
210102	Нэмэгдэл	485,836,900.0	343,307,598.0	<b>142,529,302.0</b>	<b>70.7</b>
210103	Унаа хоолны хөнгөлөлт	186,340,000.0	181,442,157.0	<b>4,897,843.0</b>	<b>97.4</b>
210104	Урамшуулал	152,014,600.0	190,029,759.5	<b>(38,015,159.5)</b>	<b>125.0</b>
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	257,727,800.0	244,729,781.2	<b>12,998,018.8</b>	<b>95.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	175,254,800.0	167,555,630.5	<b>7,699,169.5</b>	<b>95.6</b>
210202	Тэтгэмжийн даатгал	20,618,200.0	19,777,485.2	<b>840,714.8</b>	<b>95.9</b>
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,494,600.0	15,540,390.0	<b>954,210.0</b>	<b>94.2</b>
210204	Ажилгүйдлийн даатгал	4,123,700.0	3,800,037.7	<b>323,662.4</b>	<b>92.2</b>
210205	Эрүүл мэндийн даатгал	41,236,500.0	38,056,237.8	<b>3,180,262.2</b>	<b>92.3</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	36,399,200.0	36,304,600.0	<b>94,600.0</b>	<b>99.7</b>
210304	Байрны түрээс	36,399,200.0	36,304,600.0	<b>94,600.0</b>	<b>99.7</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	48,318,500.0	47,423,493.7	<b>895,006.3</b>	<b>98.1</b>
210401	Бичиг хэрэг	16,332,000.0	16,332,000.0	-	<b>100.0</b>
210402	Тээвэр, шатахуун	25,366,500.0	24,877,790.0	<b>488,710.0</b>	<b>98.1</b>
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,620,000.0	4,266,303.7	<b>353,696.3</b>	<b>92.3</b>
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.0	1,947,400.0	<b>52,600.0</b>	<b>97.4</b>
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	103,500,000.0	103,278,400.0	<b>221,600.0</b>	<b>99.8</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	83,000,000.0	82,908,400.0	<b>91,600.0</b>	<b>99.9</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	14,500,000.0	14,370,000.0	<b>130,000.0</b>	<b>99.1</b>
210604	Урсгал засвар	6,000,000.0	6,000,000.0	-	<b>100.0</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,</b>	213,027,500.0	193,729,007.0	<b>19,298,493.0</b>	<b>90.9</b>

Нийслэлийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	<b>үйлчилгээний төлбөр, хураамж</b>				
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	200,000,000.0	182,418,100.0	<b>17,581,900.0</b>	<b>91.2</b>
210803	Даатгалын үйлчилгээ	650,000.0	650,000.0	-	<b>100.0</b>
210804	Тээврийн хэрэгслийн татвар	350,000.0	350,000.0	-	<b>100.0</b>
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.0	100,000.0	-	<b>100.0</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	843,500.0	588,000.0	<b>255,500.0</b>	<b>69.7</b>
210807	Газрын төлбөр	6,900,000.0	6,818,907.0	<b>81,093.0</b>	<b>98.8</b>
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,184,000.0	2,804,000.0	<b>1,380,000.0</b>	<b>67.0</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>131,500,000.0</b>	<b>130,393,672.0</b>	<b>1,106,328.0</b>	<b>99.2</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	131,500,000.0	130,393,672.0	<b>1,106,328.0</b>	<b>99.2</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>57,546,100.0</b>	<b>52,547,060.0</b>	<b>4,999,040.0</b>	<b>91.3</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>57,546,100.0</b>	<b>52,547,060.0</b>	<b>4,999,040.0</b>	<b>91.3</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,846,100.0	24,512,224.0	<b>4,333,876.0</b>	<b>85.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,700,000.0	28,034,836.0	<b>665,164.0</b>	<b>97.7</b>
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,893,840,800.0</b>	<b>2,716,802,432.9</b>	<b>177,038,367.1</b>	<b>93.9</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,893,840,800.0</b>	<b>2,716,802,432.9</b>	<b>177,038,367.1</b>	<b>93.9</b>
132001	Орон нутгийн төсвөөс	2,893,840,800.0	2,716,802,432.9	<b>177,038,367.1</b>	<b>93.9</b>
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-	-	-
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-	-	-
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.0</b>	<b>1.0</b>	-	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0	-	<b>100.0</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>87.0</b>	<b>78.0</b>	<b>9.0</b>	<b>89.7</b>

Нийслэлийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	<b>100.0</b>
620002	Гүйцэтгэх ажилтан	86.0	77.0	<b>9.0</b>	<b>89.5</b>

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>34,611,407.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>34,611,407.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	34,611,407.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,575,952.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,575,952.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>25,035,455.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,035,455.0
<b>213</b>	<b>Урсгал шилжүүлэг</b>	<b>1,101,640.0</b>
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,101,640.0
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,101,640.0
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>35,713,047.0</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>35,713,047.0</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,315,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,474,452.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,923,595.0

### **3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 49,969.7 мянган төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа.

#### **Залруулсан алдаа:**

- Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны үр дүнг 49,969.7 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн. Энэ нь УСНББОУС-20 холбоотой талуудын тодруулга, УСНББОУС-24 төсвийн мэдээллийн толилуулга болон санхүүгийн тайлангийн “толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 68,593.3 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд 4 зөвлөмж өгсөн.

#### **3.1 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Урсгал зардлын данстай холбоотой асуудлын талаар:**

*Илрүүлэлт-1:* Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 30,438.9 мянган төгрөгийг дутуу төлсөн нь төсвийн гүйцэтгэл буруу илэрхийлэгдэх үр дагаварт хүргэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:* Өглөгийг барагдуулах, төсвийг зохистой удирдаж өр төлбөр үүсгэхгүй байх, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах

*Илрүүлэлт-2:* Барилгын дотор заслын ажлыг гүйцэтгүүлэхдээ тухайн байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгасан үйл ажиллагааны чиглэлээс өөр 36,560.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн нь төсвийн зарцуулалтад тавих хяналт сулрах үр дагавар бий болгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно” заалтыг тус тус зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:* Аж ахуйн нэгжийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийн дагуу ажил гүйлгээ, худалдан авалтыг хийж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх

*Илрүүлэлт-3:* Нийслэлийн Төрийн захиргааны авто бааз руу дуудлагын автомашины 6, 9 дүгээр сарын төлбөр 1,594.4 мянган төгрөгийг шилжүүлэхдээ өмнөх саруудын жолоочийн замын хуудсаар гүйлгээ хийсэн нь төсвийн зарцуулалтад тавих хяналт сулрах үр дагавар бий болгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заалтыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтаар баталгаажсан ажил гүйлгээг бүртгэж тайлагнаж байх.

Илрүүлэлт-4: Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй зарим тээврийн хэрэгслийн жолоочийн замын хуудасны спидометрийн заалтыг үнэн зөв хөтлөөгүй байгаа нь төсвийн зарцуулалтад тавих хяналт сулрах үр дагавар бий болгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заалтыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Жолоочийн замын тооцооны хуудсыг үнэн зөв бүртгэж байх, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах

### **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж буй 5 суудлын автомашины улсын дугаарыг цэнхэр дэвсгэрээр солиогүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4. "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ", Стандарт, хэмжилзүйн газрын даргын баталсан "MNS 4410-1-2002, Авто тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг, 1-р хэсэг : Ерөнхий шаардлага стандартын 5.4.9 дэх заалт "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй авто тээврийн хэрэгслийн улсын дугаарын дэвсгэр нь хар хөх, тоо, үсэг ба хүрээ нь цагаан өнгөтэй байна" заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авто машины улсын дугаарыг цэнхэр дэвсгэрээр сольж ашиглах хүсэлтийг холбогдох байгууллагад гаргаж шийдвэрлүүлэх зөвлөмж өглөө.

Тайлант онд 78,660.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэхдээ цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 14.4 "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг төлбөртэй сайтуудад байршуулан 2,480.0 мянган төгрөг зарцуулсан. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

#### Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТБОНӨХБАҮХАТХ хууль, тогтоомжтой холбоотой хэрэгжилтийг түүвэрлэн үзэхэд дараах зөрчил илэрлээ.

Цахим сайтад мэдээ, мэдээлэл байршуулах 23,000.0 мянган төгрөгийн ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэхдээ харьцуулсан үнийн судалгаагүй, шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 33 дугаар зүйлийн 33.1 “Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно” заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруула агүй		Тоо	Дүн
Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны үр дүнг илүү илэрхийлсэн.	1	49,969.7			1	49,969.7	1	49,969.7				
Дүн	1	49,969.7			1	49,969.7	1	49,969.7				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.	1	30,438.9					1	30,438.9				
Зарим тээврийн хэрэгслийн (71-06 УАЕ, 71-13 УАР, 71-18 УАР) жолоочийн замын хуудасны спидометрийн заалтыг үнэн зөв хөтлөөгүй байна	1	-					1	-				
Барилгын дотор засварын ажлыг улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгасан үйл ажиллагааны чиглэлээс өөр байгууллагаар гүйцэтгүүлсэн	1	36,560.0					1	36,560.0				
НТЗАБ-руу дуудлагын автомашины 6, 9 дүгээр сарын төлбөрийг шилжүүлэхдээ урд сарын жолоочийн замын хуудсаар гүйлгээ хийсэн	1	1,594.4					1	1,594.4				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>68,593.3</b>					<b>4</b>	<b>68,593.3</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс		Төлбөрийн акт		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой зөрчил								
Тайлант оны худалдан авалтаас 10 саяас дээш үнийн дүн бүхий барааг цахим дэлгүүрээс хийгээгүй	1	78,660.0			1	78,660.0		
Автомашины улсын дугаарыг цэнхэр дэвсгэрээр солиогүй	1	-					1	-
Салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг сайтад байршуулан зардал гаргасан	1	2,480.0			1	2,480.0		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Цахим сайтад мэдээ, мэдээлэл байршуулах ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэхдээ харьцуулалтын арга ашиглаагүй, шууд гэрээ байгуулсан	1	23,000.0					1	23,000.0
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>104,140.0</b>			<b>2</b>	<b>81,140.0</b>	<b>2</b>	<b>23,000.0</b>

### 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			